

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2023 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2023 оны 04 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагууд /Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба/-д **2023 оны нэгдүгээр улирлын байдлаар** иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ, тайланг нэгтгэн гаргалаа.

Эдийн засаг, хөгжлийн яаманд 2023 оны нэгдүгээр улиралд нийт 17 өргөдөл, гомдол бичиг хэргээр дамжин байгууллагын албан бичиг хөтлөлтийн программд бүртгэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн өргөдөл, гомдлын **15** өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд өргөдөл, гомдлын шийдвэрлэлт **94.11** хувийн үзүүлэлтэй байна. **1** өргөдөл хуулийн хугацаанд судлагдаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар 30 /гуч/ хоногийн хугацааг хэтрүүлж **1** өргөдлийг шийдвэрлэсэн байна.

Хугацаа хэтрүүлсэн тайлбар: 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын 3600 уурхайчдаас аж байдал, ахуй амьжиргаа, өр зээл, инфляц үнийн өсөлттэй уялдуулан 2022 оны 13 дахь сарын цалинг хоёр сараар олгож өгөхийг хүссэн хүсэлт гаргасан бөгөөд уг хүсэлтэд хариу албан бичиг боловсруулахад судалгаа хийх шаардлагатай байсан. Тодруулбал, Эрдэнэт Үйлдвэрийн уурхайчид нь төрийн албан хаагчид бус Хамтын гэрээгээр ажилладаг тул Эрдэнэт Үйлдвэрийн Хамтын гэрээг олоход хугацаа шаардагдсан болно.

Нийт ирсэн өргөдлийн **76.47** хувийг байгууллагын хүний нөөцтэй холбоотой ажилд орох өргөдөл эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хуралдаан, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд Засгийн газрын гишүүдэд өгсөн үүрэг, даалгаврын дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэж байгаа бөгөөд цаашид илүү түргэн шуурхай, иргэдэд хүндрэл чирэгдэлгүй ажиллаж, үйл ажиллагаагаа улам сайжруулахыг зорьж байна.

Жич: Тус яамны харьяа Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд 2023 оны нэгдүгээр улиралд иргэдээс Төрийн байгууллага албан тушаалтад холбогдуулан гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

/2023 оны нэгдүгээр улирлын тоон мэдээ/

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувиар
			Нийт шийдвэрлэж хариу өгсөн	Үүнээс			
				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Эдийн засаг, хөгжлийн яам	17	16	1	1	94.11%	
	Дүн	17				94.11%	

-----oOo-----

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

/Өргөдөл, гомдлын хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Үүнээс:				Бусад
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн хандсан	
1	Эдийн засаг, хөгжлийн яам	17	17	-	-	-	-
	Дүн	17	17	-	-	-	-

-----oOo-----

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

/Өргөдөл, гомдлын төрөл, агуулгаар/

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудлын нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь			
		<i>Нийт өргөдлөөс:</i>		<i>тоо</i>	<i>Эзлэх хувь</i>
1	Эдийн засаг хөгжлийн яам	1	Хүсэлт	1	5.88%
		2	Гомдол	2	11.76%
		3	Санал	1	5.88%
		Өргөдөл, гомдлын агуулга			
		1	Ажилд орохыг хүссэн	13	76.47%
		2	Бусад	-	-
			Дүн	17	

----0000000----

Хавсралт-4

2023 оны нэгдүгээр улирлын байдлаар иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдолд хамгийн олон хандалттай асуудал

№	Яамдын нэр	Эдийн засаг, хөгжлийн яам	17	13	Гар орон сууц хүссэн	Санхүүгийн дэмжлэг хүссэн	Ниймийн халамжтай холбоотой	Ниймийн даатгалтай холбоотой	Гарын харилцаатай холбоотой	Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой	Улсын бүртгэлтэй холбоотой	Салбарын үйл ажиллагаатай холбоотой	Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагаатай холбоотой
1.			17	13						1		3	